ЗДТГ	28,177.2	61,096.5	32,919.3	36.2
ОНХС	160,879.4	99,618.0	(61,261.4)	59.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>196,079.8</b>	<b>168,666.8</b>	<b>-27,413.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 238,718.3 мянган төгрөгийн бараа материалаас 209,644.2 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 29,074.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 266,131.2 мянган төгрөгийн бараа материалаас 177,560.4 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн хөгжлийн сангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 77,675.8 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	238,718.3	Хасагдсан	266,131.2
Худалдан авсан	209,644.2	Худалдсан, зарцуулсан	177,560.4
Шилжүүлсэн авсан	25,168.7	шилжүүлсэн	77,675.8
бусад	3,905.4	бусад	10,895.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,145,880.6 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,492,355.9 мянган төгрөг болж 346,475.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	2,017,480.6	2,363,955.9	346,475.3	94.8
Барилга байгууламж, орон сууц	1,352,398.6	1,545,948.6	193,550.0	62.0
Тээврийн хэрэгсэл	168,409.3	261,074.8	92,665.5	10.5
Машин тоног төхөөрөмж	264,444.4	283,666.7	19,222.3	11.4
Тавилга эд хогшил	76,461.7	92,911.7	16,450.0	3.7
Бусад үндсэн хөрөнгө	155,766.6	180,354.1	24,587.5	7.2
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	128,400.0	128,400.0	0.0	5.2
Программ хангамж	350.0	350.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	128,050.0	128,050.0	0.0	5.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,145,880.6</b>	<b>2,492,355.9</b>	<b>346,475.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 54,792.5 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13,950.0 мянган төгрөгийн мотоцикл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 295,687.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	18,849.0	16,764.5	-2,084.5	0.7
ЗДТГ	2,127,031.6	2,475,591.4	348,559.8	99.3
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,145,880.6</b>	<b>2,492,355.9</b>	<b>346,475.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 370,179.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 84.6 хувь буюу 370,179.5 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн



улсын үзлэг тооллогоор тус сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 9,809.8 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг, нийт 19,619.7 мянган төгрөгийн мотор дутагдсан тул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/382 тоот албан бичгийг үндэслэн данснаас хасаж авлагаар бүртгэсэн байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	370,179.5	Хасагдсан	23,704.10
Худалдан авсан	56,792.5	Акталсан	4,084.50
Шилжүүлэн авсан	313,387.0	Бусад	19619.6

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 140.9 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 669.3 мянган төгрөг болж 528.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	140.9	669.3	528.4	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	140.9	120.9	(20.0)	18.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг		548.4	548.4	81.9
<b>Дүн</b>	140.9	669.3	528.4	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 669.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь улсын төсвийн байгууллагын тогтмол зардлын өрийн үлдэгдэл байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	140.9		(140.9)	-
ЗДТГ		121.0	121.0	18.1
ЕБС		316.5	316.5	47.3
Цэцэрлэг		231.8	231.8	34.6
<b>ДҮН</b>	140.9	669.3	528.4	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,276,345.2 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,380,995.1 мянган төгрөг болж, 104,649.9 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	656,603.9	656,603.9	0.0	27.6
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,203,882.9	1,308,532.8	104,649.9	55.0



Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	415,858.4	415,858.4	0.0	17.5
<b>Дүн</b>	<b>2,276,345.2</b>	<b>2,380,995.1</b>	<b>104,649.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 104,649.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 8/08 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 444,635.8 мянга, хүү торгуулийн орлогыг 10,000.0 мянга, нийт 454,635.8 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.17-ний өдрийн 10/14 дугаар тогтоолоор 19,990.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	464,625.8	466,146.5	1,520.7	100.3
ЦХТА рлого /суутган/	153,890.0	178,013.3	24,123.3	115.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,500.0	2,997.9	497.9	119.9
Бууны татвар	1,000.0	1,500.0	500.0	150.0
ИОТХ	15,000.0	13,021.4	(1,978.6)	86.8
Улсын тэмдэгтийн хураамж	22,500.0	17,958.9	(4,541.1)	79.8
Хадгаламжийн хүүгийн орлого	35,000.0	30,933.2	(4,066.8)	88.4
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	4,000.0	4,526.0	526.0	113.2
Малд ногдуулах албан татвар	103,631.8	80,606.7	(23,025.1)	77.8
Ус ашигласны төлбөр	2,000.0	-	(2,000.0)	-
Газрын төлбөр	3,200.0	3,289.6	89.6	102.8
Газрын дуудлага худалдааны орлого	7,200.0	-	(7,200.0)	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,400.0	1,694.0	(2,706.0)	38.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	90,304.0	130,105.3	39,801.3	144.1
ТТАМАТөлбөр	20,000.0	1,500.0	(18,500.0)	7.5
Бусад татвар	-	0.2	0.2	#DIV/0!
2.Татварын бус орлого	10,000.0	9,975.5	(24.5)	99.8
2.1.Хүү торгуулийн орлого	10,000.0	9,975.5	(24.5)	99.8
<b>Нийт дүн</b>	<b>474,625.8</b>	<b>476,122.0</b>	<b>1,496.2</b>	<b>100.3</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 100.3 хувь буюу 1,496.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 24,123.3 бууны албан татвар 150.0 мянга, үл хөдлөх хөрөнгө



худалдан борлуулсны орлого 526.0 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 39,801.3 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин иргэний орлого тодорхойлох хуудсаар ногдуулсан албан татвар 1,978.6 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 4,066.8 мянга, малын хөлийн албан татвар 23,025.1 мянга, ашигласны төлбөр 2,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,706.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 735.0 мянган төгрөгийн орлого оруулж үүргээ биелүүлээгүй байна

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 113,160.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 60,387.2 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,910,449.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,513,668.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,111,728.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 401,940.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт №14. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Нийт зарлага ба зээлийн дүн</b>	<b>1,910,449.8</b>	<b>1,513,668.9</b>	<b>396,780.9</b>	<b>79.2</b>
<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>	<b>141,704.1</b>	<b>125,810.6</b>	<b>15,893.5</b>	<b>88.8</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	140,704.1	125,010.6	15,693.5	88.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,000.0	800.0	200.0	80.0
<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>815,980.4</b>	<b>698,049.6</b>	<b>117,930.8</b>	<b>85.5</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	507,202.5	479,955.3	27,247.2	94.6
80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	134,493.5	131,476.7	3,016.8	97.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	5,000.0	4,993.0	7.0	99.9
81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	112,019.1	44,277.5	67,741.6	39.5
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	52,865.3	33,015.0	19,850.3	62.5
82212 хур хог хаягдал, орчны бохирдол	4,400.0	4,332.1	67.9	98.5
<b>70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт</b>	<b>548,800.5</b>	<b>401,940.1</b>	<b>146,860.4</b>	<b>73.2</b>
80904 Нийгмийн зориулалттай барилга	115,986.3	30,184.7	85,801.6	26.0
83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	325,901.6	317,474.6	8,427.0	97.4
73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	3,280.8	3,280.8	0.0	100.0
83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	103,631.8	51,000.0	52,631.8	49.2
83406 ОНХС -бусад	0.0	0.0	0.0	#DIV/0!
<b>71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>48,051.4</b>	<b>44,722.7</b>	<b>3,328.7</b>	<b>93.1</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	48,051.4	44,722.7	3,328.7	93.1



71702 Соёл урлаг	58,489.5	58,189.3	300.2	99.5
80112 Нийтлэг үйлчилгээ	58,489.5	58,189.3	300.2	99.5
71801 Сургуулийн өмнөх боловсрол	30,945.8	30,938.5	7.3	100.0
80112 Нийтлэг үйлчилгээ	30,945.8	30,938.5	7.3	100.0
71802 Ерөнхий боловсрол	153,318.1	153,318.1	0.0	100.0
80112 Нийтлэг үйлчилгээ	153,318.1	153,318.1	0.0	100.0
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	113,160.0	700.0	112,460.0	0.6
82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	113,160.0	700.0	28,935.6	84.2

Эх сурвалж: Баацагаан сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 8/08 дугаар тогтоолоор нийт 1,619,066.9 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.17-ний өдрийн 10/14 дугаар тогтоолоор 291,382.9 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	140,867.5	121,438.4	141,704.1	20,265.7
Засаг даргын Тамгын газар	841,424.6	669,099.6	815,980.4	146,880.8
Сургууль	221,893.6	149,318.1	153,318.1	4,000.0
Цэцэрлэг	52,450.9	30,345.8	30,945.8	600.0
Эрүүл мэндийн төв	48,051.4	48,051.4	48,051.4	0.0
Соёлын төв	58,489.5	58,489.4	58,489.5	0.1
Сум хөгжүүлэх сан		113,160.0	113,160.0	0.0
Орон нутгийн хөгжлийн сан		429,164.2	548,800.5	119,636.3
<b>Нийт дүн</b>	<b>1,363,177.5</b>	<b>1,619,066.9</b>	<b>1,910,449.8</b>	<b>291,382.9</b>

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 8/08 дугаар тогтоолоор анх 1,619,066.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.17-ний өдрийн 10/14 дугаар тогтоолоор 291,382.9 мянган төгрөгөөр өсгөж 1,910,449.8 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 329,182.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 639,615.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 460,447.2 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 167,414.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 313,790.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Гүйцэтгэлээр орон нутгийн болон санхүүгийн дэмжлэгээс авах санхүүжилтээс 1,328,096.0 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 320,755.3 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 129,876.2 мянга, нийт 1,778,727.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 137,722.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	815,980.4	698,049.6	117,930.8	85.5	117,665.8
ИТХ	141,704.1	125,810.6	15,893.5	88.8	15,893.5
Соёлын төв	58,489.5	58,189.3	300.2	99.5	300.2
Сум хөгжүүлэх сан	113,160.0	700.0	112,460.0	0.6	-
Сургууль	153,318.1	153,318.1	-	100.0	-
Цэцэрлэг	30,945.8	30,938.5	7.3	100.0	7.3
ЭМТ	48,051.4	44,722.7	3,328.7	93.1	3,328.7
ОНХС	548,800.5	401,940.1	146,860.4	73.2	-
Нийт дүн	1,910,449.8	1,513,668.9	396,780.9	79.2	137,195.5

Эх сурвалж: Баацагаан сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,513,668.9 мянган төгрөг буюу 79.2 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 117,930.8 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 15,893.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 146,860.4 мянга, сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой 112,460 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 3,508.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3,408.7 мянган төгрөгийг зарцуулж 100.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,300.0	2,208.9	3,508.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	2,208.9	3,508.9
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,300.0	2,108.7	3,408.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300.0	2,108.7	3,408.7
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	0.0	100.2	100.2

Эх сурвалж: Баацагаан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн 1/51 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Баацагаан сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга С.Энхтөр, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Гэрэлмөнх нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 80 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,911,313.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,113.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,379.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг* шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 140 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим сайтад тендерт шалгаруулсан худалдан авах ажиллагааны 316,020.4 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 252,228.0 мянган төгрөгийн 7 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баацагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,909.6 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 21,909.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй 1 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн 1/93 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	21,909.6	1	21,909.6			100.0
Зөвлөмж	1	0	1	0			100.0
Нийт	1	21,909.6	1	21,909.6			100.0

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

#### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг



Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 52,865.3 төгрөгөөр баталж 33,015.0 мянган төгрөгийг зарцуулж 19,850.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 14 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд өвс тэжээл, элс зөөх ажилд, 86 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

#### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,910,449.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,513,668.9 мянган төгрөгийг зарцуулж 79.2 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 464,625.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 466,146.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 100.3 хувь буюу 1,496.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 24,123.3 мянга, ан агнуурын орлого 39,801.3 мянган төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой бөгөөд 9 төрлийн 64,042.1 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баацагаан сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал		Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс			
	зохио	Хамрагдсан	Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Зөрчилгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1	1			1				
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>			<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл



Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 385,345.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,400.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 162.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 362,732.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 15,050.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
ЗДТГ	3	39,235.0	1	7,400.0	1	162.0	1	31,673.0		
ОНХСан	2	56,888.5					2	56,888.5		
СХС	2	69,561.8					1	54,511.4	1	15,050.4
СТА зөрчлийн дүн	7	165,685.3	1	7,400.0	1	162.0	4	143,072.9	1	15,050.4
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
ЗДТГ	1	135,727.0					1	135,727.0		
ОНХСан	1	-					1			
ИТХурал	1	83,933.0					1	83,933.0		
Нийцлийн аудитын дүн	3	219,660.0	0	0	0	0	3	219,660.0	0	0
Нийт дүн	10	385,345.3	1	7,400.0	1	162.0	7	362,732.9	1	15,050.4

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 165,685.3 мянган төгрөгийн 7 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 385,345.3 мянган төгрөгийн 10 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		167,402.0			
1	ЗДТГ-ын дарга Б.Наранбаатарт 162.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон	162.0	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Наранбаатар Д.Анхтуяа
2	Тайлант онд урсгал засварын зардал болон хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас зарцуулсан 31,673.3 мянган төгрөгийн сэлбэгийг зарцуулсан байхад өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулаагүй.	31,673.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Наранбаатар Д.Анхтуяа
3	Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 805,910.4 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлэхээс 48,135.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 203,822.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 87,591.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.	135,727.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Наранбаатар Д.Анхтуяа
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал		83,933.0			
1	Шилэн дасны системд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлэхдээ нийт 15,693.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 68,239.5 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй байна.	83,933.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Энхтуяа Д.Должинсүрэн
Сум хөгжүүлэх сан		69,561.8			



**Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1	Баацагаан сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2017 онд зээл авсан 5 зээлдэгчийн нийт 15,050.4 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээлийг шүүхийн шатанд шилжүүлж эвлэрлийн гэрээг байгуулж байсан ба 2023 оны байдлаар бүрэн төлөгдөөгүй учир 2023.06.16-ны өдөр Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гүйцэтгэх хуудас бичүүлэх хүсэлт гаргасан боловч 2023.07.31-ны өдрийн 131/ШЗ2023/01680 дугаар захирамжаар "тус зээлдэгч нарт өмнө нь гүйцэтгэх хуудас бичсэн байна" гэх шалтгаанаар гүйцэтгэх хуудас гаргахаас татгалзсан байна.	15,050.4	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Энхтөр Б.Гэрэлмөнх Д.Должинсүрэн
2	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 15 зээлдэгчийн 54,511.4 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна.	54,511.4	Албан шаардлага	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Энхтөр Б.Гэрэлмөнх Д.Должинсүрэн
Орон нутгийн хөгжлийн сан		56,888.5			
1	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд "ДҮЙНХЭР ТЭРГҮҮН- ХХК нь "Үүрэн холбооны сүлжээ оруулах, сайтын барилга барих ажлыг гүйцэтгэх" гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэсэн хүлээлгэн өгөхөөр 52,888.5 мянган төгрөгийн гэрээг байгуулж урьдчилгаа 37,021.5 мянган төгрөгийг авсан боловч 2024.02.22-ны байдлаар ажлыг бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгөөгүй байна. ОНХС-аас 2023 онд батлагдсан төсөвт үлдэгдэл болох 15,867.0 мянган төгрөгийг тусгасан боловч гэрээний дагуу ажлыг бүрэн гүйцэтгээгүйгээс үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй байна.	52,888.5	Албан шаардлага	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Энхтөр Б.Гэрэлмөнх Д.Должинсүрэн
2	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд "МОГОЙ ХӨНДИЙ" ХХК-тай Орон нутаг судлах танхим засварлах, шилэн хорго хийх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 2023 оны 12 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөхөөр 4,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон ба одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй байна.	4,000.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	С.Энхтөр Б.Гэрэлмөнх Д.Должинсүрэн
3	Шилэн дансаны системд төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг мэдээллэхдээ сумын Засаг даргын 8 захирамжийг мэдээллэгүй байна.	0	Албан шаардлага		
Нийт дүн		377,785.3			

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 64,017.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 64,017.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### 5.1. Албан шаардлага

1. Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 464,625.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 466,146.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 100.3 хувь буюу 1,496.2 мянган төгрөгөөр давж биелсэн боловч иргэний орлого тооцох хуудсаар ногдуулсан албан татвар 1,978.6 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,541.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 4,066.8 мянга, малын хөлийн албан татвар 23,025.1 мянга, ус ашигласны төлбөр 2,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, хог хаягдлын хураамжийн хураамж 2,706.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 18,500.0 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"



5.1.1 дэх “Жинхэнэ хэрэгжилтийн”, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөж зарцуулах зөвлөмжийг хүргүүлэв.

## 5.2. зөвлөмж

1. Сумын ИТХ-аар төсөв батлахдаа Баацагаан сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж байгаа боловч Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.4 дэх “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 -д заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэний орлого тооцох хуудсаар ногдуулсан албан татвар 1,978.6 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,541.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 4,066.8 мянга, малын хөлийн албан татвар 23,025.1 мянга, ус ашигласны төлбөр 2,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, хог хаягдлын хураамжийн хураамж 2,706.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 18,500.0 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна	1	64,017.6			1	64,017.6		
Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>64,017.6</b>			<b>1</b>	<b>64,017.6</b>	<b>1</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								

-----oOo-----